



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/305

Ховд

Дархлаажуулалтын 10 хоног зохион байгуулах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 11.1.1 дэх заалт, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/207 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд “Улаанбурхан өвчинд цэг тавья” уриатайгаар дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2019 оны 5 дугаар сарын 15-аас 25-ны өдрүүдэд зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, нэмэлт дархлаажуулалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар, вакцины дагалдах хэрэгслийн хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, их дээд сургууль, коллеж, Насан туршийн боловсрол төв, Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй хаалттай хорих анги, Зэвсэгт хүчний 123 дугаар анги, салбаруудын 5-18 насны хүүхдүүдийг тархвар судлалын заалтын дагуу улаанбурхан, улаануудын эсрэг вакцинд бүрэн хамруулахыг ажлын хэсгийн ахлагч, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, /Б.Даваадорж/, Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Мягмарсүрэн/, Боловсрол соёл, урлагийн газрын дэд дарга /Д.Нарандорж/, бүх шатны Эрүүл мэндийн байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.
3. Улаанбурхан, улаанууд өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын ач холбогдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, эцэг эх, асран хамгаалагч нарт тайлбарлан таниулах ажлыг сайтар зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал эрхлэгч, хэвлэл мэдээллийн байгууллагуудын дарга, ажилтнуудад үүрэг болгосугай.

Zax A/305 Ch

02 01484


5.Орон нутагтаа дархлаажуулалтын 10 хоногийн ажлыг удирдлагаар хангаж, шаардлагатай хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэн холбогдох насны иргэдийг дархлаажуулалтанд бүрэн хамруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны Засаг дарга, энэ захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож биелэлтийг дархлаажуулалтын хугацаа дууссанаас хойш ажлын 5 өдөрт багтаан танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогч /Ч.Уранчимэг/ нарт хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2019 оны 5 дугаар
сарын 15-ны өдрийн А/305 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



ДАРХЛААЖУУЛАЛТЫН ЭЭЛЖИТ 10 ХОНОГИЙГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Б.Даваадорж -Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
- Гишүүд :
- С.Дорж -Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Ж.Батбаяр -Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн
 - Ц.Мягмарсүрэн -Эрүүл мэндийн газрын дарга
 - Д.Нарандорж -Боловсрол, соёл урлагийн газрын дэд дарга
 - Т.Бат-Өлзий -Боловсрол, соёл урлагийн газрын статистикийн асуудал хариуцсан мэргэжилтэн
 - Б.Оюунтунгалаг -Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
 - Д.Одонтуяа -Эрүүл мэндийн газрын дархлаажуулалт хариуцсан эмч
 - Б.Сайнсанаа -Боловсрол, соёл урлагийн газрын Хими биологийн боловсрол хариуцсан мэргэжилтэн
- Сумдын Засаг дарга, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн дарга, захирал, эрхлэгч нар
- Нарийн бичгийн дарга :
- Б.Одхүү -Эрүүл мэндийн газрын Халдварт өвчний сэргийлэлт хяналт, орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2019 оны 5 дугаар
сарын 15 -ны өдрийн А/ 305 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

УЛААН БУРХАН, УЛААНУУДЫН НЭМЭЛТ ДАРХЛААЖУУЛАЛТЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран ажиллах
Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар				
1.1	Улаанбурхан, улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах талаар эмнэлгийн мэргэжилтэнд зориулсан гарын авлагыг татан авч хуваарилна.	2019 оны 5 дугаар сарын 13	ЭМГ	ЭМЯ, ХӨСҮТ
1.2	Нэмэлт дархлаажуулалтанд шаардагдах вакцин, хэрэгслийг хүлээн авч, хадгалж түгээнэ	2019 оны 5 дугаар сарын 14	ЭМГ	НҮБ-ийн Хүүхдийн сан ХӨСҮТ
1.3	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд 5-18 насны хүүхдийн тоог насны ангилалаар нарийвчлан гаргана.	2019 оны 5 дугаар сарын 13-14	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд	ЭМГ, Боловсрол соёл урлагийн газар,
1.4	Нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах аймгийн болон сумдын ажлын хэсгийг томилно	2019 оны 5 дугаар сарын 15-16	ЭМГ	Аймаг, сумдын ЗДТГ, сум, өрхийн ЭМТ
1.5	Нэмэлт дархлаажуулалтын үеэр нэмэлтээр дайчлан ажиллуулах эмч сувилагч нарыг томилж ажиллуулна	2019 оны 5 дугаар сарын 15-25	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд	ЭМГ
1.6	Дархлаажуулах насны хугацаат цэргийн албан хаагчид, засан хүмүүжүүлэх газрын хүмүүжигчид, хүүхэд асрамж, халамжийн төвийн хүүхдийн тоог гаргаж, дархлаажуулалтын бичил төлөвлөгөөг боловсруулна	2019 оны 5 дугаар сарын 10-14	ЭМГ, Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд	0123 дугаар цэргийн анги, ШШГГ
1.7	Сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт нэмэлт дархлаажуулалтын талаар танилцуулга, мэдээлэл хийнэ.	2019 оны 5 дугаар сарын 13	Аймгийн ЗДТГ	Нийгмийн бодлогын хэлтэс
Хоёр. Эмч, мэргэжилтнүүдийг чадавхижуулах талаар				
2.1	Нэмэлт дархлаажуулалт	2019 оны 5	ЭМГ	Аймгийн ЗДТГ,

	зохион байгуулах, бичил төлөвлөгөө боловсруулах арга зүйд сургана.	дугаар сарын 14		БСУГ Сум, өрхийн ЭМТ
2.2	Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, вакцинатор сувилагч нарт арга зүйн сургалт зохион байгуулна.	2019 оны 5 дугаар сарын 14	ЭМГ	Аймгийн ЗДТГ, БСУГ Сум, өрхийн ЭМТ
2.3	Аймгийн ерөнхий боловсролын болон их дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн эмч, нийгмийн ажилтан нарт сургалт зохион байгуулна.	2019 оны 5 дугаар сарын 14	ЭМГ	ЗДТГ, БСУГ,
Гурав. Дархлаажуулах үйл ажиллагааны талаар				
3.1	Төрийн болон хувийн хэвшлийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, МСҮТ, коллеж, их, дээд сургуульд дархлаажуулалтын түр цэг байгуулан дархлаажуулах ажлыг зохион байгуулна.	2019 оны 5 дугаар сарын 15-25	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд	ЭМГ, БСУГ, байгууллагын дарга эрхлэгч нар
3.2	Шинээр татагдсан цэргийн албан хаагчдыг дархлаажуулна	2019 оны 5 дугаар сарын 15-25	ЭМГ, сум, өрхийн ЭМТ	0123, 0130 дугаар цэргийн ангийн удирдлагууд
3.3	Хорих ангид ял эдэлж байгаа хүмүүжигч нарыг дархлаажуулна	2019 оны 5 дугаар сарын 15-25	ЭМГ, өрхийн ЭМТ	ШШГГ-ын дарга
3.4	Сургуулиас завсардсан хөгжлийн бэрхшээлтэй гэртээ байдаг хүүхдийг дархлаажуулна	2019 оны 5 дугаар сарын 15-25	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд	Сумдын ЗДТГ, ГБХЗГ
3.5	Монгол улсад түр оршин суугаа гадаадын иргэдийг нэмэлт дархлаажуулалтад хамруулна	2019 оны 5 дугаар сарын 15-25	ЭМГ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд	Харьяа сумдын ЗДТГ
3.6	Нэмэлт дархлаажуулалтын хамралт, дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тохиолдлын мэдээг өдөр бүр авч, орон нутгийн хэмжээнд мэдээллийн сан бүрдүүлнэ	2019 оны 5 дугаар сарын 15-25	ЭМГ	ХӨСҮТ, Сум, өрхийн ЭМТ
Дөрөв. Мэдээлэл, сурталчилгааны талаар				
4.1	Улаанбурхан, улаануудын эсрэг вакцины нэмэлт дархлаажуулалтын нээлтийн арга хэмжээг зохион байгуулна	2019 оны 5 дугаар сарын 15	ЭМГ	ЗДТГ, БСГ, Сум, өрхийн ЭМТ
4.2	Нэмэлт дархлаажуулалтын талаарх мэдээллийг телевиз, радио, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр	2019 оны 5 дугаар сарын 15-25	ЭМГ, Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд	Харьяа сумдын ЗДТГ, Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд

	сурталчилна			
Тав. Дэмжлэгт хяналт, хамралтын түргэвчилсэн үнэлгээ				
5.1	Нэмэлт дархлаажуулалтын явцад дэмжлэгт хяналт хийх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.	2019 оны 5 дугаар сарын 15-25	ЭМГ	Аймгийн ЗДТГ, БСУГ
5.2	Хамралтын түргэвчилсэн үнэлгээгээр сонгогдсон нэгжийн хамралтыг үнэлэх, үнэлгээний дүнд суурилан нөхөн дархлаажуулах арга хэмжээг авна	2019 оны 5 дугаар сарын 22-оос 6 дугаар сарын 10	ЭМГ, аймгийн МХГ	ХӨСҮТ
5.3	Нэмэлт дархлаажуулалтын үйл ажиллагааны нэгдсэн тайланг холбогдох газруудад хүргүүлнэ	2019 оны 5 дугаар сарын 26	ЭМГ	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд

-оОо-

Аймгийн Засаг даргын 2019 оны 5 дугаар
сарын 15 -ны өдрийн А/ 305 дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт

СУМ, ӨРХҮҮДЭД ОЛГОХ УЛААНБУРХАН, УЛААНУУДЫН ЭСРЭГ
ХАВСАРСАН ВАКЦИН, ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН ХУВААРЬ

Д/д	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд	Хамрагдвал зохих хүний тоо	Олгох вакцин /хүн тун/	Өөрөө эвдэрдэг тариур /ширхэг/	Найруулдаг тариур / ширхэг/	Аюулгүй хайрцаг /ширхэг/
1	Алтай	945	1040	980	104	8
2	Булган	1312	1580	1580	160	13
3	Буянт	420	480	450	50	4
4	Дарви	750	830	780	85	6
5	Дөргөн	710	790	740	80	6
6	Дуут	278	310	310	32	2
7	Манхан	804	890	830	80	6
8	Мөст	905	1000	950	102	8
9	Мөнххайрхан	553	610	600	62	5
10	Мянгад	582	640	600	66	5
11	Зэрэг	773	860	830	88	7
12	Чандмань	550	620	600	65	5
13	Цэцэг	776	860	820	90	7
14	Үенч	971	1200	1000	122	9
15	Ховд	571	630	610	65	5
16	Эрдэнэбүрэн	248	270	270	28	2
17	Баатархайрхан	2264	2790	2650	282	24
18	Бугат	1462	1800	1700	189	15
19	Буянт	2913	3500	3400	360	29
20	Жаргалан	2413	2800	2800	290	23
21	Рашаант	1164	1600	1500	160	14
22	Булган өрх	1253	1400	1300	140	12
	Нийт дүн	22617	26500	25300	2700	215

-оОо-